



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/263

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.17 дахь заалт, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Япон Улсын "Зүрх хамгаалах төсөл" ашгийн бус байгууллага хооронд 2015 оны 10 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 4 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080879



МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

| № | Овог нэр | Харьяалал | Ажиллах байгууллага | Гэрчилгээний сери/дугаар | Төрөлжсөн мэргэшлийн чиглэл | Зөвшөөр лийн төрөл | Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа |
|----|---|-----------|---|-----------------------------|-----------------------------------|--------------------------|-------------------------------------|
| 1. | Ханэда Нориюки Haneda Noriyuki | Япон Улс | Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв | ГЭ0001758 | Хүүхдийн зүрх судлал | Эмчлэх | 2017-08-09 2017-08-16 7 хоног |
| 2. | Сүгияама Хисаши Sugiyama Hisashi | Япон Улс | Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв | ГЭ0001759 | Хүүхдийн зүрх судлал | Эмчлэх | 2017-08-09 2017-08-16 7 хоног |
| 3. | Тамура Масамичи Tamura Masamichi | Япон Улс | Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв | ГЭ0001760 | Хүүхдийн зүрх судлал | Эмчлэх | 2017-08-09 2017-08-16 7 хоног |
| 4. | Озава Акира Ozawa Akira | Япон Улс | Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв | ГЭ0001761 | Хүүхдийн зүрх судлал | Эмчлэх | 2017-08-09 2017-08-16 7 хоног |